



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эрдэм шинжилгээний бүтээл” (*Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology, BICCT*) сэтгүүлийн Дугаар 13 буюу 2025 оны ээлжит дугаарыг эрхэм та бүхэнд хүргэж байна. Манай сэтгүүлд сүүлийн үеийн судалгааны ажлын шинэ үр дүн, шинэлэг санаагаа нэгтгэн өгүүллээ ирүүлсэн эрдэмтэн судлаачид та бүхэндээ талархал илэрхийлье. Тус сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллүүд нь DOI дугаартай гардаг бөгөөд бид хайлтын системийн бүртгэлийг өргөжүүлэхэд ихэд анхааран ажиллаж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт эрдэс боловсруулалт, нефтийн ба нүүрсний хими, биохимийн салбараас гадна математик-химийн салбар шинжлэх ухааныг холбосон туршилтын төлөвлөлт-оновчлолын загварчлал болон интеграл тэгшитгэлийн онолыг хийн холимог системд ашиглах чиглэлээр бичигдсэн нийт 6 өгүүлэл сэтгүүлийн шаардлагыг ханган хэвлэгдэж байна. Хэвлэгдсэн бүтээлүүдээс онцолбол:

П.Манлайбаатар нарын судлаачид “К нэмэлт идэвхжүүлэгчтэй Fe-K/Al болон Co-K/Al катализаторуудын нүүрсхүчлийн хийг гидрогенжүүлэх идэвхийг харьцуулсан судалгаа”-аар Fe-K/Al болон Co-K/Al катализаторыг нүх сүвэнд шингээх аргаар бэлтгэж, нүүрсхүчлийн хийн гидрогенжуулалтын урвалын идэвх болон катализаторын шинж чанарыг харьцуулан судалж, 15.1нм талстын хэмжээтэй Fe₃O₄ нь олефины нүүрсустөрөгчид үүсгэхэд, харин 17.5нм талстын хэмжээтэй CoO нь парафины нүүрсустөрөгчдийг үүсгэхэд тус тус идэвхийн төв болж байгааг тогтоожээ. Түүнчлэн судлаач П.Саранцэцэг нар Монголын нүүрсний ордуудаас цуглуулсан каолинит агуулсан хаягдал шаврын дээжүүдийн эрдсийн болон химийн бүрэлдэхүүнийг судалж, тэдгээр хаягдлаас каолинитын эрдсийн агуулгыг нэмэгдүүлэн, цэвэршүүлэх боломжит аргыг боловсруулсан байна.

Нөгөөтэйгүүр манай орны эрдэс боловсруулалтын салбарт хөндөгдөж буй асуудлуудын нэг болох зэсийн бага агуулгатай полиметаллын баяжмалыг нам температурт исэлдүүлэн шатааж, үүссэн зэсийн нэгдлийг ус болон хүхрийн хүчлийн уусмалд уусган, электролизын аргаар өндөр цэвэршилттэй металл зэс (Cu⁰) ялгах судалгаа болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зэс-молибден баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усанд ууссан ионууд (Ca²⁺, Fe³⁺, Cu²⁺, Mo⁴⁺)-ын концентрацын өөрчлөлт молибденитийн баяжигдах чанарт хэрхэн нөлөөлж байгааг Design of Experiments статистик шинжилгээний аргаар тогтоосон талаарх үр дүнгүүд хэвлэгдэж байна.

Харин ургамлын химийн судлаачид Монголын уламжлалт анагаах ухаанд шарх эдгээх, үрэвсэл дарах зорилгоор хэрэглэдэг Наран холтсон цэцэг (*Ranunculus japonicus Thunb.*) ургамлын газрын дээд хэсгийн антиоксидант идэвх болон ялгасан цэвэр бодисын бүтцийг тогтоох судалгааг явуулж, уг ургамал нь байгалийн гаралтай өндөр идэвхтэй антиоксидантын чухал эх үүсвэр байж болохыг харуулсан үр дүнг гаргажээ.

Мөн дулааны цахилгаан станцын дэгдэмхий үнс болон үнсэн сангийн үнснээс нэмүү өртөг шингэсэн дэвшилтэт шинэ материал болох синосферыг ялган авч, гарц ба физик-химийн шинж чанарыг харьцуулан судалсан судалгааны ажлыг материал судлаачид хийжээ. Манай сэтгүүлтэй нэгэн сэтгэлээр хамтран ажиллаж буй хөндлөнгийн шүүмжлэгч нартаа талархал илэрхийлэхийн сацуу эрхэм эрдэмтэн судлаач та бүхнийг эрдэм шинжилгээний шинэхэн өгүүллүүдээ ирүүлэхийг урьж байна.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР ЛХАСҮРЭНГИЙН ЖАРГАЛСАЙХАН